

БАТЛАВ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр

## НИСЛЭГ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВӨӨС “ЧИНГИС ХААН” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ЧИГЛЭЛД ШИЛЭН КАБЕЛИЙН ШӨРМӨС ТҮРЭЭСЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР


### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн даалгавар нь нислэг хөдөлгөөний удирдлагын төвөөс Чингис хаан Олон улсын нисэх буудлын чиглэлд агаарын навигацийн мэдээлэл дамжуулах цагариг сүлжээний нөөц холболтын шугамд ашиглагдах шилэн кабелийн сүлжээний техникийн үзүүлэлтүүдийг тусгасан болно.

### 2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Шилэн кабелийн сүлжээ түрээслүүлэх байгууллага нь дараах техникийн шаардлагыг бүрэн хангасан байна.

- Шилэн кабелийн сүлжээ түрээслүүлэх байгууллага нь “Мэдээлэл холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах (Хот, хот хооронд) ангиллын зөвшөөрөл” эзэмшигч байх.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын өөрийн мэдлийн шилэн кабелийн трасстай давхцаагүй буюу Иргэний нисэхийн ерөнхий газар-> Биокомбинат-> Шувуун фабрик->”Чингис Хаан” Олон улсын нисэх буудал чиглэлд Зураг №1 үзүүлсэн трасс дагуу өөрийн мэдлийн шилэн кабельтай байх.
- Түрээсийн хугацаанд түрээслүүлэгч нь шилэн кабелийн сүлжээний найдвартай ажиллагааг хангаж ажиллах бөгөөд гэмтэл саатал гарсан тохиолдолд түрээслэгчид мэдэгдэж түргэн шуурхай засварлана.
- Түрээслүүлэгч нь төлөвлөгөөт техник үйлчилгээ хийхдээ 48 цагийн өмнө мэдэгдэж түрээслэгчийн тохиромжтой цагт хийнэ.



Зураг №1

### 3. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Түрээслүүлэх шилэн кабелийн техникийн үзүүлэлтүүд нь доорх шаардлагыг бүрэн хангасан байна.

№	Техникийн үзүүлэлт
1	Түрээслүүлэх шилэн кабелийн шөрмөс нь дан горимтой 1270nm-1610nm долгионы урттай гэрлийн дохиог дамжуулах бүрэн боломжтой байх.
2	Иргэний нисэхийн ерөнхий газраас Чингис Хаан Олон улсын нисэх буудал хүртэлх нийт кабелийн урт нь 50км-ээс бага буюу CWDM төхөөрөмж ажиллах хүрээнд байна.
3	Түрээслүүлэх шилэн кабелийн шөрмөсний унтралт буюу Return loss нь 18dB-ээс бага байна.

### 4. ШИЛЭН КАБЕЛИЙН СҮЛЖЭЭ ТҮРЭЭСЛЭХ ТОО ХЭМЖЭЭ

№	Сэлбэгийн нэр	Хэмжих нэгж	Түрээслэх тоо	Техникийн үзүүлэлт
1	Дан горимтой шилэн кабелийн шөрмөс	ширхэг	2	3-т заагдсан техникийн үзүүлэлтүүдийг бүрэн хангасан байна.

### 5. БАРИМТ БИЧИГ

Дараах бичиг баримтуудыг ирүүлнэ. Үүнд:

- 5.1 Мэдээлэл холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах (Хот, хот хооронд) ангиллын зөвшөөрлийн гэрчилгээ
- 5.2 Өөрийн байгууллагын үйлчилгээний танилцуулга
- 5.3 Кабель шугамын трасс зураг

### 6. ХОЛБОЛТ, ТУРШИЛТ

- 6.1 Шилэн кабелийн холболтыг Иргэний нисэхийн ерөнхий газрын тоног төхөөрөмжийн өрөө болон Чингис Хаан Олон улсын нисэх буудлын Зорчигч үйлчилгээний барилгын сервер тоног төхөөрөмжийн өрөөнд байрлах Иргэний нисэхийн ерөнхий газрын шилэн кабелийн хуваарилах хайрцгууд дээр хийнэ.
- 6.2 Шилэн кабелийн сүлжээний холболтын ажлыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хийгдэж дууссан байна.
- 6.3 Түрээслүүлэгч нь шаардлагад нийцсэн шилэн кабелийн сүлжээний үйлчилгээ үзүүлэх ба холболтын ажлыг Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэхийн Холбоо, навигаци, ажиглалтын албаны ажилтнуудтай хамтарч гүйцэтгэнэ.

### 7. ХҮЛЭЭН АВАХ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлтийг шалгаж, ажил хүлээн авах актыг үйлдсэнээр түрээсийн үйлчилгээг эхэлсэнд тооцно.

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний Нисэхийн холбоо,  
навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн  
Радио холбооны тасгийн ахлах инженер;



Д.Оюунболд

Иргэний нисэхийн үндэсний төвийн, Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан  
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн;



Э.Уянга

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”  
Төрийн бус байгууллагын гишүүн;  
(тохиролцсоноор);



Б.Мэндсайхан